



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА
ХЭМЖЭЭ ТӨЛӨВЛӨСӨН ҮР ДҮНД ХҮРЭЭГҮЙ БАЙНА.**

**2022 оны 04
дүгээр сар**

**АУДИТЫН СЭДЭВ: УЛСЫН ТӨСВИЙН 2021 ОНЫ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

2022 он

АГУУЛГА

АГУУЛГА.....	2
Товчилсон үгийн тайлбар	4
Хүснэгтийн товъёг.....	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	6
А. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ БАГА БАЙНА.....	8
А.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний 52.6 хувь нь аймгийн ТЕЗ-ын саналд үндэслэгдсэн байна.....	8
А.1.1 Батлагдсан төсөл арга хэмжээний 80.2 хувийг бодлогын баримт бичигт нийцүүлж төлөвлөсөн байна	8
А.1.2 Батлагдсан төсөл арга хэмжээний 81.8 хувь нь салбарын бодлогод, 52.6 хувь нь аймгийн ТЕЗ-ын саналд үндэслэсэн байна	9
А.1.3 ТЕЗ-ийн саналд үндэслэгдээгүй 9 төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний жагсаалтад оруулан баталсан байна.....	10
А.2 Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнгүй байна	10
А.2.1 Шинээр хэрэгжих барилга байгууламжийн 8 төсөл арга хэмжээний зураг төсөв төлөвлөлтийн шатанд бэлэн болоогүй байжээ	10
А.2.2 Барилга байгууламжийн зураг төслийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд боловсруулсан байна.....	11
А.2.3 Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох төсөв зардлыг бүрэн шилжүүлсэн эсэхэд тооцоо хийх боломжгүй байна.....	11
А.2.4 Барилга байгууламжийн 3 ТАХ-ний зураг төсөл нь холбогдох хууль тогтоомж, барилгын норм ба дүрэм, төсвийн үнэ бүрдэл, төсөв зохиох дүрмийн дагуу магадлалаар орж баталгаажаагүй байна	12
А.2.5 Барилга байгууламжийн магадлалаар баталгаажсан өртөг нь батлагдсан төсөвт өртгөөс материаллаг зөрүүтэй байна	13
А.3 Төсөл арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилт хангалтгүй байна.....	14
А.3.1 Хэрэгцээ, шаардлагагүй, эсвэл хэрэгцээ шаардлагаас бага хүчин чадалтай төсөл арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна	14
А.3.2 Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй байна.....	14
А.3.3 Төсөл арга хэмжээг, хугацаандаа хэрэгжих байдлаар тооцож, санхүүжилтийг баталсан байна.....	15
А.3.4 Шинээр хэрэгжих төсөл арга хэмжээнд хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл арга хэмжээ төлөвлөгдөөгүй байна	15
Б. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.....	16
Б.1. Зарим тендер шалгаруулалтыг хууль журамд нийцүүлж зохион байгуулаагүйгээс тендертэй холбоотой маргаан гарсан байна	16
Б.1.1. ТЕЗ-даас төсөл, арга хэмжээг хуульд заасан хугацаанаас 18-42 хоногоор хэтрүүлж эрх шилжүүлжээ	16
Б.1.2. Худалдан авах ажиллагааг тайлант онд хэрэгжих боломжийг хангахуйцаар зохион байгуулж ажиллаагүй байна	17
Б.1.3. Зарим тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлээгүй байгаа нь гомдол гарахад нөлөөлсөн байна	18
Б.1.4. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна	20
Б.1.5. Худалдан авах ажиллагааны тайланг хугацаанд нь тайлагнасан боловч шилэн дансаар дамжуулан олон нийтэд мэдээлээгүй байна.....	21
Б.2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж ажиллаагүй байна	21
Б.2.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 56 хувь нь гэрээний хугацаанд хийгдээгүй байна.....	21
Б.2.2. Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагаас хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.....	24
Б.2.3. Хөрөнгө оруулалтаар авсан зарим тоног төхөөрөмж хэрэглэгчдэд бүрэн хүрээгүй байна	25
Б.2.4. Тус аймагт өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй орхигдсон 7 барилга байгууламж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.....	27

Б.2.5. Барилга байгууламжийн 4 төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төслийг барилгын норм, дүрэм, стандартын дагуу боловсруулсан байна	27
Б.3. Төсөл арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.....	27
Б.3.2 Төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгож ирсэн байна.....	28
Б.3.3 Хөрөнгө оруулалтын явцад Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.....	29
Б.4. Засгийн газраас гарсан шийдвэрийн хэрэгжилт үр дүнтэй болсон байна	30
Б.4.1. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан санхүүжилтийг төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд зарцуулсан байна	30
Б.4.2. Засгийн газраас ТЭЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд өмнөх онуудад байршуулсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна	30
Б.5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцож ажиллаагүй байна	31
Б.5.1. Нийлүүлсэн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй, хүчин чадлаар нь зориулалтын дагуу ашиглаагүй байна.....	31
Б.5.2. Төсөвт өртөг нь үндэслэлгүй нэмэгдсэн төсөл, арга хэмжээ байхгүй байна.....	32
Б.5.3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна	32
Б.5.4. Тайлант онд хэрэгжихээр төлөвлөгдсөн төсөл арга хэмжээний 32 хувь нь ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл арга хэмжээнд чиглэгдсэн байна.....	33
Б.5.5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд авто замын хүчин чадал 6.5 км-ээр нэмэгдсэн	33
ДҮГНЭЛТ:.....	34
ЗӨВЛӨМЖ:.....	35
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ.....	36

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дэд байгууллагын олон улсын стандарт
БХБС	Барилга хот байгуулалтын сайд
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
СС	Соёлын сайд
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ЗТХС	Зам тээврийн хөгжлийн сайд
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХНХС	Хөдөлмөр, нийгмийг хамгаалах сайд
ХХААХҮС	Хүнс хөдөө аж ахуй хөнгө үйлдвэрийн сайд
ХЗДХЯ	Хууль зүй дотоод хэргийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЕЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөө бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ҮАГ	Үндэсний аудитын газар
ШӨХТГ	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар

Хүснэгтийн товьёг

Хүснэгт 1	Төсөл арга хэмжээний магадлалаар баталгаажуулсан өртөг, огноо	13
Хүснэгт 2	Төсөл арга хэмжээний эрх шилжүүлсэн хугацаа	16
Хүснэгт 3	Худалдан авах ажиллагааны хугацаа	18
Хүснэгт 4	Гэрээний гүйцэтгэл, санхүүжилт	29

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоолоор баталсан аудитын сэдэв, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөг үндэслэн хийв.

Аудитын зорилт

Баян-Өлгий аймагт хэрэгжсэн “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх,
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, улсын төсвөөс олгосон санхүүжилтийн зарцуулалт үр дүнтэй байгаа эсэх

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд санхүүжүүлэхээр баталсан 22 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий төрийн захиргааны болон бусад байгууллага, аймгийн Засаг дарга түүний харьяа байгууллага болон төсөл арга хэмжээг гүйцэтгэгч нарын холбогдох үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэлээ.

Аудитын хязгаарлалт

Байхгүй

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг гүйцэтгэхэд Аудитыг АДБОУБ (INTOSAI)-ын стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүй, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам, Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал, арга зүйг ашиглан ҮАГ-аас ирүүлсэн асуудлын шинжилгээ, арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, судалгаа, дүн шинжилгээ хийж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган хянан удирдаж, аудитын менежер Х.Женисбек чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор М.Айнур, аудитор У.Ербол нар хамтран гүйцэтгэв.

Аудитын талбарын ажлыг 2022 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс 2022 оны 04 дүгээр сарын 22-ны хооронд гүйцэтгэж, тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан аймгийн Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж, 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ҮАГ-аас болон холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлнэ.

Хүндрэл бэрхшээл

А. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТИЙН ТОГТОЛЦООНЫ ҮР НӨЛӨӨ БАГА БАЙНА

А.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний 52.6 хувь нь аймгийн ТЕЗ-ын саналд үндэслэгдсэн байна

А.1.1 Батлагдсан төсөл арга хэмжээний 80.2 хувийг бодлогын баримт бичигт нийцүүлж төлөвлөсөн байна

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн 15 дугаар тогтоолоор Баян-Өлгий аймагт нийт 22 төсөл арга хэмжээг эрх шилжүүлжээ. Үүнд:

- ЗГХЭГ-ын даргын багцаас 1, ХНХС-ын багцаас 1, БХБС-ын багцаас 2, БШУС-ын багцаас 7, ЗТХС-ын багцаас 2, ХХААХҮС-ын багцаас 1, ЭМС-ны багцаас 7, Соёлын сайдын багцаас 1 төсөл арга хэмжээг тус тус шилжүүлсэн байна.

ТЕЗ-даас 2021 онд эрх шилжүүлсэн 19 төсөл арга хэмжээг Улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд нийцсэн эсэхийг шалгаж үзэхэд:

А.Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөрт БСШУС-ын 5 төсөл арга хэмжээ, Харилцаа, холбооны салбарын хүртээмж, чанартай холбоотой 1 төсөл арга хэмжээ тусгагдаж, 13 төсөл арга хэмжээ тусгагдаагүй байна. Үүнд:

- Өлгий сумын 100 ортой цэцэрлэгийн барилга 2 ш, 940 суудалтай сургуулийн барилга, спорт заал, Булган сум, Сайхан баг 50 ортой цэцэрлэгийн барилга, Шилэн кабельд холбох, зураг төсөв боловсруулах 5 төсөл арга хэмжээ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөрийн 2 дугаар бодлогын 7, 14 дэх заалтад тусгагджээ.
- Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга, Хот тохижилтын парк шинэчлэл, Ерөнхий боловсролын сургуулиудын компьютерийн лабораторийн тоног төхөөрөмж, Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам 3.1 км, Бугат сум Хатуугийн голын гүүрийн зураг төсөв, Хүнс, хөдөө аж ахуйн газрын лабораторийн барилга, Ногооннуур сум, Улаанхад багийн 5 ортой эрүүл мэндийн төвийн барилга, Нэгдсэн эмнэлгийн түргэн тусламжийн машин, Цэнгэл, Улаанхус, Ногооннуур, Буянт сумын Эрүүл мэндийн төвийн түргэн тусламжийн машин, Өлгий, Улаанхус, Цэнгэл, Дэлүүн, Булган, Улаанхус сум, Аймгийн Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эхо аппарат, нярайн халаах төхөөрөмж, инкубатор нийлүүлэх 13 төсөл арга хэмжээ тусгагдаагүй байна.

Б. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт ЗГХЭГ-ын дарга, ХНХС, БХБС-ын багцаас тус бүр 1, БШУС-ын багцаас 6, ЭМС-ын багцаас 7, бүгд 16 төсөл арга хэмжээ тусгагдаж, 3 төсөл арга хэмжээ тусгагдаагүй байна. Үүнд:

- Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам 3.1 км, Бугат сум Хатуугийн голын гүүрний зураг төсөв, Хүнс, хөдөө аж ахуйн газрын лабораторийн барилга 3 төсөл арга хэмжээ Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй.

- Бусад 16 төсөл арга хэмжээ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.12, 2.1.4.2, 2.1.4.4, 2.6.1.8, 2.2.3, 2.3.9, 2.3.11, 3.5.7, 2.5.8 дахь заалтуудад тусгагджээ.

В. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд 18 төсөл арга хэмжээ тусгагдаж, 1 төсөл арга хэмжээ тусгагдаагүй байна. Үүнд:

- Хүнс, хөдөө аж ахуйн газрын лабораторийн барилга 1 төсөл арга хэмжээ тусгагдаагүй.
- Бусад 18 төсөл арга хэмжээ Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.2.4, 2.4.5, 6.4.7, 9.1.1, 9.2.4 дэх заалтуудад тусгагджээ.

Г. Баян-Өлгий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх “Хөгжилд тэмүүлсэн Баян-Өлгий” үйл ажиллагааны хөтөлбөр, Баян-Өлгий аймгийн 2021 оны хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан эсэхийг шалгаж үзэхэд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 19 төсөл арга хэмжээ нь Баян-Өлгий аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 2.1.8, 2.1.10, 2.2.4, 3.3.4, 8.1.1, 8.1.6, 8.1.7 дахь заалтуудад тус тус тусгагджээ.
- Хүнс, хөдөө аж ахуйн газрын лабораторийн барилга аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдаагүй, бусад 18 төсөл арга хэмжээ аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.2.1, 2.5.1, 6.1.1, 3.6.2, 3.8.1, 6.2.2, 6.2.3, 6.2.2.4 дэх заалтуудад тусгагдсан байна.

Дээрх байдлаас дүгнэж үзэхэд 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 19 төсөл арга хэмжээний 80.2 хувийг холбогдох бодлогын баримт бичгүүдэд нийцүүлж төлөвлөсөн байна.

А.1.2 Батлагдсан төсөл арга хэмжээний 81.8 хувь нь салбарын бодлогод, 52.6 хувь нь аймгийн ТЕЗ-ын саналд үндэслэсэн байна

Засгийн газрын 2021 оны 15 дугаар тогтоолоор Баян-Өлгий аймагт эрх шилжүүлсэн 22 төсөл арга хэмжээ нь салбарын бодлого, ТЕЗ-ын саналд үндэслэсэн эсэхийг шалгаж үзэхэд:

Салбарын бодлогод ороогүй Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам 3.1 км, Бугат сум Хатуугийн голын гүүрний зураг төсөв, Хүнс, хөдөө аж ахуйн газрын лабораторийн барилга 3 төсөл арга хэмжээг жагсаалтад оруулан баталсан байна.

Хүнс, хөдөө аж ахуйн газрын лабораторийн барилга Аймгийн ТЕЗ-ын саналд ороогүй бөгөөд жагсаалтад оруулан баталжээ.

Монгол Улсын 2021 оны төсвийн хуулиар батлагдаж, Засгийн газрын 2021 оны 15 дугаар тогтоолоор тус аймагт эрх шилжүүлсэн Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 22 төсөл арга хэмжээний 3 нь 2020 оноос шилжих төсөл арга хэмжээ байна.

Бусад 19 төсөл арга хэмжээний 11 нь аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслэгдэж, дараах 9 төсөл арга хэмжээ ТЕЗ-ийн саналд үндэслэгдээгүй байна.

- Улаанхус сум, Хөххөтөл баг Шилэн кабельд холбох, зураг төсөв боловсруулах
- Хот тохижилтын парк шинэчлэл

- Өлгий сум 100 ортой цэцэрлэгийн барилга 2 ш
- Булган сум, Сайхан баг 50 ортой цэцэрлэгийн барилга
- Өлгий сум 940 суудалтай сургуулийн барилга, спорт заал
- Баяннуур сумын 1, 3, 5 дугаар багийн сургуулийн спорт заалны барилга
- Хүнс, хөдөө аж ахуйн газрын лабораторийн барилга
- Ногооннуур сум, Улаанхад багийн 5 ортой эрүүл мэндийн төвийн барилга

Үүнээс үзэхэд Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл хөтөлбөр арга хэмжээний 81.8 хувь нь салбарын бодлогод, 52.6 хувь нь ТЕЗ-ын саналд үндэслэсэн байна.

А.1.3 ТЕЗ-ийн саналд үндэслэгдээгүй 9 төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээний жагсаалтад оруулан баталсан байна

Аймгийн Засаг даргын 2021 оны 4 дүгээр сарын 01-ны өдрийн 1-01/520, 1-01/522 дугаар албан бичгээр сумын Засаг дарга, харьяа агентлагуудын дарга нарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагаа хөтөлбөртэй уялдуулан боловсруулж, хавсралтаар хүргүүлсэн судалгааны маягтын хамт хүргүүлж, санал хүсэлтийг нь авсан байна.

Аймгийн Засаг даргын харьяа агентлаг, сумын Засаг дарга нараас ирүүлсэн саналд аймгийн ЗДТГ-аас оруулсан саналыг нэмж, нийт 99 төсөл арга хэмжээг эрэмбэлж, Сангийн Сайдын 2018 оны 295 дугаар тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх, төсөл арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх, сонгох аргачлал”-ын 2.2.1-2.2.7-д заасан үзүүлэлтээр үнэлж, оноо өгсөн байна.

Барилга байгууламжийн нийт 22 төсөл арга хэмжээнд 42-75.5 хооронд оноо өгч, 77 төсөл арга хэмжээ нь их засвар, тоног төхөөрөмж тул оноо өгөгдөөгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс ТЕЗ-ийн хөрөнгө оруулалтын саналын төслийг нэгтгэн аймгийн Засаг даргын 2020 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 2-01/311, 2-01/310, 2-01/308, 2-01/309 дугаар албан бичгээр Сангийн яамны Хөрөнгө оруулалтын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, БШУЯ-д, ЭМЯ-д тус тус хүргүүлсэн байна.

Мөн Улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгах төсөл арга хэмжээний төслийг 2020 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн 1-01/754, 1-01/753, 1-01/752, 1-01/755, 1-01/758, 1-01/756, 1-01/757 дугаар албан бичгээр ЭМЯ, ХЗДХЯ, Сангийн яам, ЗТХЯ, ЗГХЭГ, БХБЯ, БШУЯ-д тус тус хүргүүлсэн байна.

Гэтэл ТЕЗ-ийн саналд үндэслэгдээгүй 9 төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад оруулан баталсан байна.

А.2 Барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийх тогтолцоо үр дүнгүй байна

А.2.1 Шинээр хэрэгжих барилга байгууламжийн 8 төсөл арга хэмжээний зураг төсөв төлөвлөлтийн шатанд бэлэн болоогүй байжээ

Барилга байгууламжийн 13 ажлаас /барилга барих/ 3 нь өмнөх оноос шилжих хөрөнгө оруулалт, 10 нь шинээр хэрэгжих төсөл арга хэмжээ байна. Шинээр хэрэгжих

10 төсөл арга хэмжээний 2 төсөл арга хэмжээний зураг төсвийг төлөвлөлтийн шатанд бэлтгэж, 8 төсөл арга хэмжээ нь зураг төсөвгүй байжээ.

Зураг төсвийг төлөвлөлтийн шатанд бэлтгэсэн төсөл арга хэмжээ нь:

- Баяннуур сумын 1, 3, 5 дугаар багийн сургуулийн спорт заалны барилга
- Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 3.1 км

Эдгээр төсөл арга хэмжээний геологийн дүгнэлт, холбогдох техникийн нөхцөлүүд, газрын зөвшөөрөл нь бүрэн олгогдсон байна.

А.2.2 Барилга байгууламжийн зураг төслийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд боловсруулсан байна

Тайлант онд зам гүүр, барилга байгууламжийн 10 төсөл арга хэмжээний зураг төсвийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий 11 хуулийн этгээд зураг төсөл зохиох ажлын даалгаврыг техникийн нөхцөл, геологийн дүгнэлт, газрын зөвшөөрөл зэрэгт үндэслэн боловсруулсан байна.

Шилэн кабельд холбох, зураг төсөв боловсруулах /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөххөтөл баг/ ажил нь 5 багцтай бөгөөд 3, 4, 5 дугаар багцын ажлыг өөр өөр компани боловсруулсан байна.

А.2.3 Барилга, байгууламжийн зураг төсөл зохиох төсөв зардлыг бүрэн шилжүүлсэн эсэхэд тооцоо хийх боломжгүй байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэх эрх шилжсэн 22 төсөл арга хэмжээний 9 нь бараа, тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл арга хэмжээ бөгөөд барилга байгууламжийн 13 төсөл арга хэмжээний зохиогчийн хяналт болон захиалагчийн хяналтын зардлыг тухайн төслийн гэрээ, хийсэн ажлын гүйцэтгэлийн дагуу холбогдох норм, дүрэмд заасныг үндэслэн, зураг төсөл зохиогчийн хяналтын зардлын гүйцэтгэлийн нэгдсэн актаар хянаж тухайн төсөл дээр байгаа гэрээ, хийсэн ажлын гүйцэтгэлийг үндэслэн Санхүү, төрийн сангийн хэлтсээс шилжүүлсэн байна.

Үүнээс Зам, тээврийн хөгжлийн сайдын багцаас 2 төсөл, арга хэмжээний зураг, төсөл зохиогчийн хяналтын зардлын санхүүжилтийг орон нутгаар дамжуулаагүй яамнаас шууд олгожээ.

Барилга байгууламжийн 13 төсөл арга хэмжээний зураг төслийн гэрээний үнэ 665.1 сая төгрөг байна.

Зураг төслийн үнэ болон зохиогчийн зардлыг Санхүү, төрийн сангийн хэлтэс олгосон эсэхийг бүрэн хэмжээгээр тооцоо хийх боломжгүй байна. Учир нь төлөвлөлтийн шатанд зураг төсөв нь бэлтгэгдээгүй, түлхүүр гардуулах нөхцөлөөр худалдан авсан 8 төсөл арга хэмжээний зураг төслийн зардлыг компаниуд өөрсдөө олгосон байна.

Тайлант оны санхүүжилтийн баримтаас зохиогчийн хяналтын зардалд 17.3 сая төгрөг шилжүүлсэн дүнтэй байна.

А.2.4 Барилга байгууламжийн 3 ТАХ-ний зураг төсөл нь холбогдох хууль тогтоомж, барилгын норм ба дүрэм, төсвийн үнэ бүрдэл, төсөв зохиох дүрмийн дагуу магадлалаар орж баталгаажуулж байна

Төсвийн ерөнхийлөн захирагчдаас эрх шилжүүлсэн шинээр болон шилжин хэрэгжих барилга байгууламжийн 13 төсөл арга хэмжээ, тендерийн маргаан, бусад шалтгаанаар 2020 оноос шилжиж ирсэн 2 төсөл арга хэмжээ нийт 15 төсөл арга хэмжээнээс 4 төсөл арга хэмжээний зураг төсөл нь төлөвлөлтийн шатанд бэлтгэгдсэн байна.

Үүнээс: Их засварын 1 төсөл арга хэмжээ нь ажлын даалгаврын дагуу зураг төсөл нь хийгдсэн, магадлалд орохгүй ажил байна.

Барилга байгууламжийн түлхүүр гардуулах нөхцөлөөр худалдан авсан 10 төсөл, арга хэмжээ нь Засгийн газрын 2019 оны 108 дугаар тогтоолоор баталсан “Барилга, байгууламжийн зураг төсөв боловсруулах, магадлал хийх дүрэм”-ээр магадлал хийлгэх шаардлагатай барилга, байгууламж байна.

Үүнээс 2021 онд 7 барилгыг норм ба дүрэм, төсвийн үнэ бүрдэл болон төсөв зохиох дүрмийн дагуу магадлалаар оруулж баталгаажуулсан байна.

Харин Өлгий сумын 100 ортой цэцэрлэгийн барилга, 940 суудалтай сургуулийн барилга, спорт заал, “Кутты мекен” цэцэрлэгийн барилга 3 төсөл арга хэмжээний зураг төсөл нь 2021 онд магадлалаар орж баталгаажуулж байна.

Зураг төсөл нь магадлалаар орж баталгаажуулж байхад 2 төсөл арга хэмжээнд Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 7.2.2 дахь заалтыг зөрчиж ажлыг нь эхлүүлж, санхүүжилт олгосон байна. 1 төсөл арга хэмжээ нь 2021 онд ажлаа эхлээгүй байна.

- “Кутты мекен” 120 ортой цэцэрлэгийн барилгын зураг төсөл нь магадлалаар баталгаажуулж гараагүй байхад барилгын суурийн ажлыг 2021 онд хийлгэж, гүйцэтгэгч “Көшелик” ХХК-д 200.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд зураг төслийн магадлалын дүгнэлт 2022 оны 2 дугаар сарын 28-нд гарсан байна.
- Өлгий сумын 940 суудалтай сургуулийн барилга, спорт заалны зураг төсөв магадлалаас гарч баталгаажуулж байхад ажлыг 2021 онд эхлүүлж гүйцэтгэгч “Турлиахт” ХХК-д 200.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон бөгөөд зураг төслийн магадлалын дүгнэлт 2022 оны 4 дүгээр сарын байдлаар гараагүй байна.

Энэ нь Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.5-д “энэ хуулийн 10.1.2, 10.1.3-т заасан ангилалд хамаарах улс, орон нутгийн төсөв, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр барих барилга, байгууламжийн төсөв, нэгдсэн төсөв”, 25.4-д “Энэ хуулийн 25.2, 25.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгээгүй бол барилгын ажлын зөвшөөрөл олгохыг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

А.2.5 Барилга байгууламжийн магадлалаар баталгаажсан өртөг нь батлагдсан төсөвт өртгөөс материаллаг зөрүүтэй байна

Төсөл арга хэмжээнүүдээс Өлгий сумын 940 суудалтай сургуулийн барилга, спорт заал, 100 ортой цэцэрлэгийн барилгын зураг төсөл нь магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажаагүй байна.

Бусад төсөл арга хэмжээнүүдийн магадлалд орж баталгаажсан зураг төслийн төсөвт өртөг нь батлагдсан төсөвт өртгөөс 265.1-4873.9 сая төгрөгийн хооронд материаллаг дүнгийн зөрүүтэй гарсан байна.

Хүснэгт № 01

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Шинэ/Шилжих	Батлагдсан төсөвт өртөг	Магадлалын он сар өдөр, бүртгэлийн дугаар	Магадлалаар баталгаажсан өртөг	Зөрүү
1	Шилэн кабельд холбох, зураг төсөв боловсруулах /Баян-Өлгий, Улаанхус сум, Хөххөтөл баг/ 3-р багц , 5-р багц	шинэ	226.0	2021.9.30 1473/2021, 2021.10.15 1614/2021	272.9	46.9
2	Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/	шинэ	1,930.0	2021.12.16	6803.9	4,873.9
3	Баян-Өлгий аймгийн Бугат сумын Халуун усны барилгын ажил	шилжих хөрөнгө оруулалт	295.1	2020.07.07	296.5	1.4
4	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Баян-Өлгий, Булган сум, Сайхан баг/	шинэ	750.0	2022.03.10, №309/2022	1924.0	1,174.0
5	Цэцэрлэгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум/	шинэ	1,500.0	2021.12.16 2048/2021	2413.6	913.6
6	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Баян-Өлгий, Ногооннуур сум, Улаан байшинт боомт/	шилжих хөрөнгө оруулалт	450.0	2021.11.17, №1823/2021	1388.5	938.5
7	Баяннуур сумын 1,3,5 дугаар багийн сургуулийн спорт заалны барилга	шинэ	1,620.0	2021.06.25, №824/2021	2496.9	876.9
8	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 3.1 км /Баян-Өлгий, Өлгий сум/	шинэ	2,800.0	2021.03.15, №19/2021	3164.7	364.7
9	Хүнс, хөдөө аж ахуйн газар, лабораторийн барилга /Баян-Өлгий, Өлгий сум/	шинэ	1,913.2	2021.10.04, №1514/2021	2178.3	265.1
10	Багийн эрүүл мэндийн төвийн барилга, 5 ор /Баян-Өлгий, Ногооннуур сум, Улаанхад баг/	шинэ	377.6	2021.10.26, №1546/2021	788.9	411.3
11	Соёлын төвийн барилга, 300 суудал /Баян-Өлгий, Толбо сум/	шилжих хөрөнгө оруулалт	1,683.2	2020.07.31, №1397/2020	1683.1	(0.1)
12	Цэцэрлэгийн барилга, 120 ор /Баян-Өлгий, Өлгий сум, Кутты мекен хотхон/	өмнөх оноос шилжиж ирсэн	800.0	2022.02.28	2393.7	1,593.7
13	Цэцэрлэгийн барилга, 50 ор /Баян-Өлгий Баяннуур сум, Акарал баг	өмнөх оноос шилжиж ирсэн	380.0	2021.11.02 1725/2021	889.3	509.3
	Нийт дүн		14,725.1		26,694.3	11,969.2

Эх сурвалж: Баян-Өлгий аймгийн 2021 оны УТХО-ынТАХ-ний судалгаа

Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилгын магадлалаар баталгаажсан өртөг төсөвт өртгөөс 4,873.9 сая төгрөгөөр, Булган сумын 50 ортой цэцэрлэгийн барилга 1,174.0 сая төгрөгөөр, Өлгий сум 100 ортой цэцэрлэгийн барилга 913.6 сая төгрөгөөр, Ногооннуур сум, Улаан байшинт боомт 50 ортой цэцэрлэгийн барилга 938.5 сая төгрөгөөр, Баяннуур сумын 1, 3, 5 дугаар багийн сургуулийн спорт заалны барилга 876.9 сая төгрөгөөр, Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам 3.1 км 364.7 сая төгрөгөөр, Хүнс, хөдөө аж ахуйн газрын лабораторийн барилга 265.1 сая төгрөгөөр, Ногооннуур сум, Улаанхад багийн 5 ортой эрүүл мэндийн төвийн барилга 411.3 сая төгрөгөөр, Өлгий сум, “Кутты мекен” хотхон 120 ортой цэцэрлэгийн барилга 1,593. 0 сая төгрөгөөр, Баяннуур сумын Акарал баг 50 ортой цэцэрлэгийн барилга 509.3 сая төгрөгөөр тус тус илүү байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасныг зөрчиж байгаа бөгөөд төсөл арга хэмжээнүүдийг Улсын Их хуралд оруулж батлуулахдаа зураг төсөл нь хийгдсэн, магадлал хийгдсэн байх шаардлагыг харгалзаагүй батлуулсантай холбоотой байна.

Шинээр хэрэгжих төсөл арга хэмжээний төлөвлөлтийн шатанд зураг төслийг бэлтгэж, магадлалд оруулж байх, магадлалд орж баталгаажаагүй төсөл арга хэмжээг төсөл арга хэмжээний жагсаалтад тусгахгүй байхыг аймгийн ЗДТГ, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэст зөвлөмж болголоо.

А.3 Төсөл арга хэмжээг үр ашигтай төлөвлөх бодлогын хэрэгжилт хангалтгүй байна

А.3.1 Хэрэгцээ, шаардлагагүй, эсвэл хэрэгцээ шаардлагаас бага хүчин чадалтай төсөл арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна

Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл арга хэмжээ дотор хэрэгцээ шаардлагагүй, эсвэл хэрэгцээ шаардлагаас бага хүчин чадалтай төсөл арга хэмжээ төлөвлөгдөөгүй байна.

А.3.2 Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй байна

Аймгийн Засаг даргын захирамжаар Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг үнэлж, эрэмбэлэх үйл ажиллагааны журам болон холбогдох аргачлалуудыг батлах тухай” журмын 3.2-т заасны дагуу салбарын төлөөллүүдийг оролцуулсан 5 хүний бүрэлдэхүүнтэй төслийн сонгон шалгаруулах орон тооны бус ажлын хэсэг байгуулж ажиллаагүй байна.

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс нь Засаг даргын харьяа агентлагууд, сумын Засаг дарга нараас ирүүлсэн саналыг журамд заасан тусгай шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдол, төслийн бэлэн байдлын оноо өгч үнэлж, зохих журмын дагуу эрэмбэлж, нэн тэргүүний ач холбогдолтой төслүүдийг тодорхойлж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг гарган хуулийн хугацаанд Сангийн яам болон бусад холбогдох яамдад хүргүүлсэн байна.

Хүлээн авсан саналын жагсаалтыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл арга хэмжээг шалгаруулсан байна.

Батлагдсан төсөл арга хэмжээний жагсаалтад ТЭЗҮ, зураг төсөл нь бэлэн болоогүй байсан 8 төсөл арга хэмжээ батлагдсан нь Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох аргачлал”-ын 2.4, Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.1.1, 2.2, 6.1, 7.2 дахь заалттай нийцэхгүй байна.

Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох журмыг мөрдөж ажиллахыг аймгийн ХОХБТХ-т зөвлөмж болголоо.

А.3.3 Төсөл арга хэмжээг, хугацаандаа хэрэгжих байдлаар тооцож, санхүүжилтийг баталсан байна

Тус аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжих 19, шилжих хөрөнгө оруулалтын 3, бүгд 22 төсөл арга хэмжээг 9015.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр эрхийг нь шилжүүлсэн байна.

Төсөл арга хэмжээнүүдийг санхүүжүүлэхэд ЗГХЭГ-ын даргын багцаас 600.0 сая төгрөгийн 1, ХНХС-ын багцаас 422.4 сая төгрөгийн 1, БШУС-ын багцаас 3420.0 сая төгрөгийн 7, ЭМС-ын багцаас 1381.6 сая төгрөгийн 7, БХБС-ын багцаас 795.1 сая төгрөгийн 2, ЗТХС-ын багцаас 1080.0 сая төгрөгийн 2, ХХААХҮС-ын багцаас 500.0 сая төгрөгийн 1, СС-ын багцаас 1000.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээний төсөв батлагдсан байна.

Дээрхи төсөл арга хэмжээнээс 12 төсөл арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг батлуулсан байна. Үүнд:

Баян-Өлгий аймгийн Бугат сумын Халуун усны барилга, Ерөнхий боловсролын сургуулиудын компьютерийн лабораторийн тоног төхөөрөмж, Ногооннуур сум Улаанбайшинт боомт 50 ортой цэцэрлэгийн барилга, Баяннуур сумын 1, 3, 5 дугаар багийн сургуулийн спорт заалны барилга, Бугат сум Хатуугийн голын гүүрийн зураг төсөв, Ногооннуур сум, Улаанхад багийн 5 ортой эрүүл мэндийн төвийн барилга, Нэгдсэн эмнэлгийн түргэн тусламжийн автомашин, Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн тоног төхөөрөмж, Аймгийн Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгийн багаж, хэрэгсэл, Булган сум эрүүл мэндийн төвийн суурин эхо аппарат, Улаанхус сум Эрүүл мэндийн төвийн нярайн халаах төхөөрөмж, инкубатор, Цэнгэл, Улаанхус, Ногооннуур, Буянт сум түргэн тусламжийн автомашин зэрэг төсөл арга хэмжээг тайлант хугацаанд хэрэгжүүлэхээр тусгасан байна.

А.3.4 Шинээр хэрэгжих төсөл арга хэмжээнд хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл арга хэмжээ төлөвлөгдөөгүй байна

Тус аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжих төсөл арга хэмжээнд хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл арга хэмжээ төлөвлөгдөөгүй байна.

Б. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

Б.1. Зарим тендер шалгаруулалтыг хууль журамд нийцүүлж зохион байгуулаагүйгээс тендертэй холбоотой маргаан гарсан байна

Б.1.1. ТЕЗ-даас төсөл, арга хэмжээг хуульд заасан хугацаанаас 18-42 хоногоор хэтрүүлж эрх шилжүүлжээ

Төсвийн ерөнхийлөн захирагчдаас 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 19 төсөл, арга хэмжээний эрхийг тус аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” 04 дүгээр тушаалаар 1 төсөл, арга хэмжээ, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/60 тоот тушаалаар 6 төсөл, арга хэмжээ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн А/18 дугаар тушаалаар 1 төсөл, арга хэмжээ, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн А/80 дугаар тушаалаар 7 төсөл, арга хэмжээ, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн 34 дүгээр тушаалаар 1 төсөл арга хэмжээний эрхийг аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна.

Хүснэгт №02

№	ТЕЗ-ын нэр	Төсөл, арга хэмжээний тоо	Эрх шилжүүлэх эцсийн хугацаа	Эрх шилжүүлсэн хугацаа	Хугацаа хоцроож шилжүүлсэн хугацаа
1	ЗГХЭГ	1	2021.01.13	2021.01.15	2
2	БШУСайд	6	2021.01.13	2021.02.24	41
3	ХНХСайд	1	2021.01.13	2021.02.19	36
4	ЭМСайд	7	2021.01.13	2021.02.25	42
5	ЗТХСайд	2	2021.01.13		
6	БХБСайд	1	2021.01.13	2021.02.10	27
7	ХХААХҮСайд	1	2021.01.13		
	Нийт	19			18-42 хоног

Эх сурвалж: ТЕЗ-даас эрх шилжүүлсэн ТАХ-ний нэгдсэн судалгаа

Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах” журмын 2.13-д заасны дагуу төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор эрх шилжүүлэх ёстой байсан боловч хугацаанаас 18-42 хоногоор хэтрүүлж эрх шилжүүлсэн байна. Тухайлбал:

Боловсрол, шинжлэх ухааны сайд 6 төсөл арга хэмжээг 41 хоногоор, Эрүүл мэндийн сайд 7 төсөл арга хэмжээг 42 хоногоор, Барилга, хот байгуулалтын сайд 1 төсөл арга хэмжээг 27 хоногоор, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд 1 төсөл арга хэмжээг 36 хоногоор тус тус хугацаа хэтрүүлэн эрх шилжүүлжээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчдаас эрх шилжүүлсэн хугацаа нь хуулийн хугацаанаас дунджаар 33 хоногоор хэтэрсэн нь тендер зарлах хугацаанд нөлөөлж, төлөвлөсөн зарим төсөл арга хэмжээнүүд хугацаанд хэрэгжихгүй байх эрсдэл үүсгэсэн байна.

Эрх шилжүүлэх хугацаа нь 60 хоног боловч 18-42 хоногоор хугацаа хоцроож эрх шилжүүлж байгаа нь улирлын чанартай хийгддэг барилгын ажлууд тухайн онд бүрэн хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

Б.1.2. Худалдан авах ажиллагааг тайлант онд хэрэгжих боломжийг хангахуйцаар зохион байгуулж ажиллаагүй байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд шинээр хэрэгжүүлэх эрх шилжүүлсэн 19 төсөл арга хэмжээний 15 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанаас дунджаар 36 хоногоор хоцроож тендер зарлаж, 69 хоногоор хоцроож гэрээ байгуулсан байна.

Хүснэгт №03

№	Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр	Тендер			Гэрээний		
			Зарлахаар төлөвлөсөн огноо	Зарласан огноо	Тендерг зарцуулсан нийт	Байгуулахаар төлөвлөсөн огноо	Байгуулсан огноо	Үүнээс, хэтэрсэн хоног
1	2	3	4	5	6	7	8	9
1	V.3.1.2	Шилэн кабельд холбох, зураг, төсөв боловсруулах	2021.04.05	2021.05.21	46	2021.04.05	2021.07.08	93
2	XI.1.1.9	Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга	2021.03.22	2021.04.16	24	2021.05.10	2021.06.17	37
3	XII.3.2	Хот тохижилтын парк шинэчлэл	2021.04.12	2021.05.20	38	2021.05.20	2021.06.30	40
4	XII.1.44	Халуун усны барилга /Баян-Өлгий, Бугат сум/	2021.04.12	2021.04.20	8	2021.05.20	2021.06.22	32
5	XVII.1.13	ХААГ-ын, лабораторийн барилга Өлгий сум/	2021.03.26	2021.05.27	61	2021.05.01	2021.07.09	68
6	XIV.1.36	Соёлын төвийн барилга, 300 суудал / Толбо сум/	2021.05.05	2021.04.05, 2021.10.11	0	2021.06.01	2021.12.14	194
7	XIII.1.1.229	Цэцэрлэгийн барилга, 100 ор /, Өлгий сум/	2021.03.25	2021.05.21	56	2021.06.01	2021.08.10	70
8	XIII.1.1.231	Цэцэрлэгийн барилга, 100 ор /, Өлгий сум/	2021.03.17	2021.05.13	56	2021.06.01	2021.08.12	72
9	XIII.1.1.166	Цэцэрлэгийн барилга, 50 ор / Баяннуур сум, Акарал баг	2020.02.20	2020.06.26 2021.04.12	146	2020.04.01	2021.06.04	423
10	XIII.1.2.14	Алтанцөгц сумын сургуулийн хичээлийн А байрны спорт заалны засварын ажил	2020.02.20	2021.6.31	151	2020.04.01	2021.02.03	302
11	XIII.1.1.167	Цэцэрлэгийн барилга, 50 ор / Ногооннуур сум, Улаанбайшинт боомт/	2021.05.05	2021.05.13	8	2021.06.01	2021.08.02	61
12	XIII.1.1.230	Цэцэрлэгийн барилга, 50 ор / Булган сум,	2021.03.15	2021.05.14	61	2021.06.01	2021.08.06	65

13	XIII.1.1.215	Баяннуур сумын 1,3,5-р багийн сургуулийн спорт заалны барилга	2021.03.22	2021.08.02	130	2021.06.01	2021.10.04	123
14	XV.2.4.1	Хатуугийн голын гүүрийн зураг, төсөв / Бугат сум/	2021.03.01	2021.04.09	38	2021.05.01	2021.07.02	61
15	XV.1.1.55	Аймгийн төвийн хатуу хучилттай авто зам, 3.1 км / Өлгий сум/	2021.03.01	2021.04.02	31	2021.05.01	2021.05.21	20
НИЙТ ДҮН					854	-	-	1,661
		Дундаж хоног			36	-	-	69

Эх сурвалж: tender.gov.mn сайт, ХАА-ны баримт

Улаанхус сумын Хөх хөтөл багийг Шилэн кабельд холбох, зураг, төсөв боловсруулах ажил, Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга, Хүнс, хөдөө аж ахуйн газрын лабораторийн барилга, Өлгий сумын 100 ортой цэцэрлэгийн барилга 2ш, Булган сумын 50 ортой хүүхдийн цэцэрлэг, Өлгий сумын сургуулийн барилга 940 суудалтай, спорт заал, Ногооннуур сумын Улаан байшинтын 50 ортой цэцэрлэгийн барилга, Хүнс, хөдөө аж ахуйн лабораторийн барилга, Ногооннуур сумын Улаанхад багийн 5 ортой Эрүүл мэндийн төвийн барилга зэрэг ажлуудын зураг төсөв, ТЭЗҮ, ажлын даалгавар тухайн үед бэлэн болоогүй, нийт 11 төсөл арга хэмжээнд тендер шалгаруулалттай холбоотой тендерт оролцогч компаниудаас Сангийн яам болон шүүхэд гомдол гаргаснаас шалтгаалан тендер нь товлосон хугацаандаа зарлагдаагүй, хугацаа хэтэрсэн байна.

Дээрх 15 төсөл арга хэмжээний тендер төлөвлөсөн хугацаанаас 20-423 хоногоор хугацаа хожимдож зарлагдсанаас тухайн онд хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдийн үр дүнд нөлөөлж, төсөл арга хэмжээнүүд нь тайлант онд бүрэн хэрэгжээгүй байна.

Тендерийг хугацаа хожимдуулан зарлаж, гэрээ байгуулсан нь дээрх шалтгаантай холбоотой боловч нөгөө талаар Орон нутгийн өмчийн газраас худалдан авах ажиллагааг хугацаанд төлөвлөж ажиллаагүй, тендерийн үнэлгээний хорооны гишүүдийн ажлын хариуцлагатай холбоотой байна.

Тендерийг төлөвлөсөн хугацаанаас хожимдуулан зарлаж байгаа асуудалд дүгнэлт хийж, худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд түргэн, шуурхай зохион байгуулж ажиллахыг Орон нутгийн өмчийн газарт зөвлөмж болгов.

Б.1.3. Зарим тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлээгүй байгаа нь гомдол гарахад нөлөөлсөн байна

Аймгийн Орон нутгийн өмчийн газар нь тендерийн баримт бичгийг худалдан авах ажлын төрөл болон худалдан авах ажиллагааны хэлбэрээс шалтгаалан Сангийн яамнаас баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягт, тендер шалгаруулалтад холбогдох бусад журам аргачлалын дагуу бэлтгэн боловсруулан цаасаар болон цахим хэлбэрээр бүрдүүлэн ажилласан байна.

Гэтэл зарим тендерийн баримт бичгийг хууль тогтоомж, журамд нийцүүлээгүйгээс тендертэй холбоотой маргаан гарч зарим төсөл арга хэмжээ тухайн онд хэрэгжээгүй, тендерийн маргаан өмнөх онтой харьцуулахад нэмэгдсэн байна. Тухайлбал:

Бугат сумын халуун усны барилгын тендерийн бичиг баримттай холбоотой “Көркем” ХХК-аас ШӨХТГазарт, “Найрамдал оргил” ХХК-аас Сангийн яам, Захиргааны хэргийн анхан шат, давж заалдах шатны шүүхэд тус тус гомдол гаргасан байна.

Толбо сумын 300 суудалтай Соёлын төвийн барилгын тендер шалгаруулалттай холбоотой “Лаулау” ХХК-аас Захиргааны хэргийн анхан шатны болон давж заалдах шатны шүүхэд гомдол гаргажээ.

Ногооннуур сумын Улаан байшинт боомтын 50 ортой цэцэрлэгийн барилгын тендерийн бичиг баримттай холбоотой “Их түргэн ачит” ХХК-аас тендерийн хороонд гомдол гаргаж, тендерийн бичиг баримтад өөрчлөлт оруулсан, “Өлкө констракшн” ХХК-аас Сангийн яамд гомдол гаргаж, тендер шалгаруулалтын үнэлгээг дахин хийсэн байна.

Булган сумын Сайхан багийн 50 ортой цэцэрлэгийн барилгын худалдан авах ажиллагаатай холбоотой “Лаулау” ХХК-аас Сангийн яамд гомдол гаргаснаар тендерийн үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийсэн байна.

Ногооннуур сумын Улаанхад багийн 5 ортой Эрүүл мэндийн төвийн барилгын тендертэй холбоотой “Классиксолюшн” ХХК-аас Сангийн яамд гомдол гаргажээ.

Алтанцөгц сумын сургуулийн хичээлийн А байр, биеийн тамирын их засварын ажлын худалдан авах ажиллагааг 2020 онд зохион байгуулсан боловч үнэлгээ хийгдээгүй шалтгаанаар худалдан авах ажиллагаа нь хүчингүй болсон байна. Тендерт оролцогч “Көркем” ХХК нь шүүхэд үнэлгээ хийлгэх талаар нэхэмжлэл гаргаж, шүүхийн шийдвэрийн дагуу тендерийн үнэлгээг дахин хийжээ.

Өлгий сумын 100 ортой цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэгчээр “Классиксалюшн” ХХК шалгарсан боловч “Чандмань-Уушир” ХХК Сангийн Яам болон Шүүхэд гомдол гаргасан.

Өлгий сумын 940 суудалтай сургуулийн барилга, спорт заал ажлын гүйцэтгэгчээр “Турлиахт” ХХК шалгарсан боловч, “Агайын” ХХК нь Шүүхэд гомдол гаргасан.

Өлгий сум 100 ортой цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэгчээр “Нур едил” ХХК шалгарсан боловч “Хатан түнгэл” ХХК шүүхэд гомдол гаргасан байна.

Баяннуур сумын Ах арал багийн 50 ортой цэцэрлэгийн барилгын ажлын тендерийг 2020 онд шалгаруулж, гүйцэтгэгчийг шалгаруулсан боловч маргаан гарч, Сангийн яамд гомдол гаргаж, тендер хүчингүй болж 2021 онд дахин зарласан.

Дэлүүн, Улаанхус, Цэнгэл сумын сум дундын эмнэлгүүдийн тоног төхөөрөмж нийлүүлэхээр 3-4 дүгээр багцад зарласан тендертэй холбоотой “Био мед” ХХК-аас Сангийн яамд гомдол гаргаж, тендер шалгаруулалтын үнэлгээг дахин хийжээ.

Тайланд онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 24 төсөл, арга хэмжээний 11 буюу 45.8%-д тендертэй холбоотой гомдол гарсан байна.

Зарим тендерийн бичиг баримт боловсруулсан байдлыг судалж үзэхэд Ногооннуур сумын Улаан байшинт боомтын 50 ортой цэцэрлэгийн барилгын тендерийн бичиг баримтын ТООЗ 6.3 /в/-д “...ерөнхий инженер, инженер техникийн

ажилчид 100% компанийн үндсэн ажилтан байна”, ТООЗ 13.1 /ж/-д “ ажлын даалгаврыг судалж тооцно” гэж ТББ-д тусгасан боловч тендер шалгаруулалтад уг заалтыг мөрдөөгүй,

Булган сумын Сайхан багийн 50 ортой цэцэрлэгийн барилгын тендерийн бичиг баримтын ТООЗ 13.1 /ж/-ийн 10-т “.....гэрээний үнэ, ажлын даалгавар, техникийн нөхцөлийн дагуу зураг төсөл, барилга угсралтын ажлыг гүйцэтгэн ашиглалтад хүлээлгэн өгнө” гэсэн заалтыг “Лау-лау” ХХК нь хангасан боловч тооцоогүй,

Бугат сумын халуун усны барилгын тендерийн бичиг баримтын ТООЗ 5.3 /а/-д “Сүүлийн 2 жилийн буюу 2019, 2020 оны дундаж нь төсөвт өртгийн үнийн дүнгийн 100%-аас багагүй байх”, ТООЗ 5.3 /в -д “гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн тоног төхөөрөмж, машин механизмууд нь 100 % тендерт оролцогчийн эзэмшлийнх байх” гэсэн шалгуурууд нь ямар үндэслэлээр оруулсан нь тодорхой бус, шаардлагыг хангаж байгаа аж ахуйн нэгжийн талаар судалгаа мэдээлэлгүйгээр тендерийн баримт бичигт оруулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т “Худалдан авах ажиллагаанд ил тод, өрсөлдөх тэгш боломжтой, үр ашигтай, хэмнэлттэй, хариуцлагатай байх зарчмыг баримтална” гэсэн заалтуудад нийцээгүй байна.

Аудитын дүнгээр худалдан авах ажиллагааг хугацаанд төлөвлөх, зарим төсөл арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлээгүй, тендер шалгаруулалтыг хууль журмын дагуу зохион байгуулаагүйгээс гомдол гарч байгаа асуудалд дүгнэлт хийж, худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд төлөвлөж, түргэн, шуурхай зохион байгуулж ажиллах, аж ахуйн нэгжүүдийг ил тод, тэгш өрсөлдөх боломжоор хангаж ажиллахыг Орон нутгийн өмчийн газарт зөвлөмж болгов.

Сангийн яам болон бусад холбогдох байгууллага, анхан болон давж заалдах шатны шүүхэд аж ахуйн нэгжүүдийн гаргасан гомдол нь үндэслэлтэй боловч нөгөө талаар худалдан авах ажиллагааг санаатайгаар гацаах, шалгарсан компаниудад тохиролцох гэсэн санаа байгааг үгүйсгэх аргагүй юм. *Тухайлбал:*

Бугат сумын халуун усны барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулахтай холбоотой “Көркем” ХХК-иас ШӨХТГ-т, “Найрамдал оргил” ХХК-аас Сангийн яам, Баян-Өлгий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны давж заалдах шүүхэд гомдол гаргасан ч давж заалдах шатны шүүхээс магадлал гарч хэрэгсэхгүй болгосон байна.

Тухайн онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээнүүдийн ихэнх нь хэрэгжиж дуусаагүй байгаа нь дээрх тендерийн маргаантай холбоотой байна.

Б.1.4. Гүйцэтгэгчийг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж, сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан байна

Төсвийн ерөнхийлөн захирагч нараас 2021 онд аймгийн Засаг даргад эрх шилжүүлсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга байгууламж 11, их засварын 1, зөвлөх үйлчилгээ 1, авто машин, тоног төхөөрөмжийн 8, бүгд 21 ажлын тендерийн гүйцэтгэгчийг аймгийн Орон нутгийн өмчийн газраас сонгон шалгаруулсан байна.

Тус аймгийн 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тендер шалгаруулалттай холбоотой мэдээлэл, тендерт шаардлагатай бүрдүүлэх материал, урилгыг хэвлэл, цахим сайтаар олон нийтэд нээлттэй мэдээлж, тендер шалгаруулалтыг зарлахдаа тендерийн урилга болон холбогдох баримтуудыг

“tender.gov.mn”, tender.bo.gov.mn” сайтад нийтэд байршуулан мэдээлж, сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж ажилласан байна.

Б.1.5. Худалдан авах ажиллагааны тайланг хугацаанд нь тайлагнасан боловч шилэн дансаар дамжуулан олон нийтэд мэдээлээгүй байна

Аймгийн Орон нутгийн өмчийн газраас Төсвийн ерөнхийлөн захирагчдын багцад батлагдсан хөрөнгө оруулалтын ажлаас эрх шилжүүлсэн 19 төсөл арга хэмжээг худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 2021 оны худалдан авах ажиллагааны тайланг Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах” журмын дагуу гаргаж, хуулийн хугацаанд Сангийн яамд хүргүүлсэн байна.

Харин 2021 оны худалдан авах ажиллагааны дүн, тайланг шилэн дансаар дамжуулан олон нийтэд мэдээлээгүй байна. Аудитын дүнгээр худалдан авах ажиллагааны тайланг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаанд нь байршуулан мэдээлж ажиллахыг зөвлөмж болгов.

Б.2. Захиалагч гэрээний хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж ажиллаагүй байна

Б.2.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 56 хувь нь гэрээний хугацаанд хийгдээгүй байна

Төсвийн ерөнхийлөн захирагчдаас 2021 онд эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын 22 төсөл арга хэмжээ, өмнөх оноос дамжин хэрэгжсэн 6 төсөл арга хэмжээ, бүгд 28 төсөл арга хэмжээ байна. Үүнээс: 2021 онд хэрэгжих 16 төсөл арга хэмжээ байгаа бөгөөд гэрээнд заасан хугацаанд 7 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 9 төсөл арга хэмжээ хугацаанд хэрэгжээгүй байна.

Хэрэгжиж дууссан 7 төсөл арга хэмжээг улсын комиссын актаар захиалагч байгууллагуудад ашиглалтад хүлээлгэн өгсөн байна. Хугацаандаа хэрэгжээгүй 9 төсөл арга хэмжээний 6 нь барилга угсралт, 3 нь тоног төхөөрөмжийн ажил байна.

Барилга байгууламжийн хувьд:

Толбо сумын Соёлын төвийн барилгын ажлын тендертэй холбоотой маргаан гарч анхан болон давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасны улмаас ажил гүйцэтгэх гэрээг жилийн эцэст байгуулж төлөвлөсөн ажил огт хийгдээгүй,

Булган сумын Сайхан багийн 50 ортой цэцэрлэгийн барилгын ажлын тендерийн бичиг баримттай холбоотой Сангийн яамд гомдол гаргасан, барилга барих газар нь тусгай хамгаалалттай газарт орсон асуудлаар ажил нь хийгдээгүй байна.

Ногооннуур сумын Улаанхад багийн 5 ортой Эрүүл мэндийн төвийн барилгын зураг төсвийг магадлалаар баталгаажуулахаар хугацаа алдсан, гэрээний хэрэгжилт 88.5 %-тай байна.

Баяннуур сумын 1, 3, 5-р багийн сургуулийн спорт заалны барилгын ажлын тендерийг анх түлхүүр гардуулах нөхцөлөөр зарлахаар захирамж гарсан боловч зураг төсөв бэлэн болтол тендер шалгаруулалтыг түр хойшлуулж ажил гүйцэтгэх гэрээг 2021 оны 10 дугаар сард байгуулснаас төлөвлөсөн ажил нь хугацаандаа хийгдээгүй байна. "Көркем" ХХК-ийн 1-р багцын ажлын гүйцэтгэл 20%-тай,

"Нармаржан" ХХК-ийн 2-р багцын гүйцэтгэл 31.5%-тай, "Досстрой" ХХК-ийн 3-р багцын гүйцэтгэл 49.8%-тай байна.

Өлгий сумын 100 ортой цэцэрлэгийн барилгын ажил нь тендер шалгаруулалттай холбоотой гомдол гарснаас хэрэгжээгүй.

Улаанхус сумын Хөх хөтөл багийн шилэн кабельд холбох, зураг төсөв боловсруулах ажлын 1-р багц ажил нь цар тахлын нөлөөгөөр бараагаа хугацаанд нийлүүлээгүйгээс 5-р багцын шилэн кабель татах газар шорооны ажил хугацаанд хийгдээгүй хойшлогдсон байна.

Өлгий сумын "Кутты мекен" хотхонд баригдаж буй /шилжих/ 120 ортой цэцэрлэгийн барилгын ажлыг 2020-2021 онд хэрэгжүүлж дуусахаар төлөвлөсөн боловч тухайн үед техникийн нөхцөл нь олгогдоогүй, магадлалд оруулах хугацаа нь хойшлогдсон тул ажил гүйцэтгэх гэрээг 2022 оны 7 сарын 20-ны өдрийг хүртэл сунгасан. Гэрээний хэрэгжилт 33.5 %-тай байна.

Тоног төхөөрөмжийн хувьд:

Ерөнхий боловсролын сургуулиудын компьютерийн лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын 10-р багцад шалгарсан "Монтех Дистрибьюшн" ХХК нь "Ковид-19" цар тахлын улмаас 110.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлээгүй тул санхүүжилт олгогдоогүй.

Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн нярайн халаах инкубатор төхөөрөмж нийлүүлэх ажил мөн дээрх шалтгаанаар бүрэн хэрэгжээгүй 94.9 %-тай байна.

Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын тендерийн 3-р багцад шалгарсан "Еба констракшн" ХХК нь 6.3 сая төгрөгийн үнэ бүхий 14 ширхэг үзлэгийн орыг, 2-р багцад шалгарсан "Сүвэн уул" ХХК нь 19.5 сая төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг тус тус дутуу нийлүүлсэн байна.

Өлгий сумын Хот тохижилтын парк шинэчлэл, Улаанхус сумын Хөх хөтөл багийн 1-р багцын шилэн кабельд холбох, зураг төсөв боловсруулах ажил нь ковид-19 цар тахлын нөлөөгөөр хил хаалттай, улс хоорондын тээвэр удаашралттай байгаатай холбоотой нийлүүлэх барааг татаж авч чадаагүй байна. Холбогдох компаниудаас аймгийн ЗДТГ-т хүсэлт ирүүлж, Шилэн кабельд холбох, зураг төсөв боловсруулах ажлын 1-р багцын гэрээг сунгуулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гэрээний хугацааг хэтрүүлж байгаа нь тендерийн маргаан, газрын асуудал шийдэгдээгүй, зураг төсвийг магадлалаар баталгажуулаагүй, Ковид-19 цар тахлын хязгаарлалттай холбоотой шаардлагатай материалыг хугацаандаа татаж авч чадаагүй зэрэг шалтгаантай холбоотой байна.

Төсөл арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг газар дээр шалгаж үзэхэд дараах байдалтай байна.Үүнд:

- Өлгий сумын 4-р багт баригдаж буй 100 ортой Цэцэрлэгийн барилгын ажил 2021 онд барилгын суурийг цутгаж, суурийг элсээр дүүргэсэн, өрөлт хийхэд бэлэн болгож, нийт 30 хувийн ажлыг гүйцэтгэсэн тайлан гаргасан байна. 2022 оны 4 сарын байдлаар барилгын ажлаа эхлүүлээгүй байна.



- Өлгий сумын 5 дугаар багт баригдаж буй 250 ортой Цэцэрлэгийн барилгын ажил нь 2021 онд бэлтгэл ажлаа хийсэн. 2022 оны 4 сард барилгын ажлын суурийн ажлыг дуусгасан байна.



- Өлгий сумын “Кутты мекен” хотхонд байршилтай 120 ортой Цэцэрлэгийн барилгын ажил нь барилгын суурийг цутгаж, ханын өрлөгийг хийж гүйцэтгэх явцад гаргасан зөрчилтэй холбоотой МХГ-аас шалгалт хийж, ажлыг зогсоосон байна. Уг ажлын зураг төсөв нь магадлалаар орж баталгаажаагүй байхад ажлаа эхлүүлсэн зөрчилтэй байна.



- Өлгий сумын сургуулийн барилга 940 суудал, спорт заалны ажил нь зураг төсөв нь магадлалд орж баталгаажаагүй байхад ажлаа эхэлсэн зөрчилтэй байна. 2022 оны 4 сараас ажлаа эхлүүлсэн байна.



- Баяннуур сумын Акарал багийн 50 ортой цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэл 87.6 хувьтай байна.



- Алтанцөгц сумын сургуулийн хичээлийн А байр, биеийн тамирын заалны их засварын ажлын гүйцэтгэл 91.1 хувьтай байна.



Б.2.2. Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагаас хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга, засварын ажлын захиалагчийн үүргийг ГХБХБГазар орон нутагт хэрэгжүүлэхээр Барилгын хөгжлийн

төвтэй 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдөр № 2021/28 тоот гэрээ байгуулж, нийт 20 төсөл, арга хэмжээнд техникийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга, Хүнс, хөдөө аж ахуйн газрын лабораторийн барилгын ажлын техникийн хяналтыг Барилга захиалагчийн алба аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу хэрэгжүүлсэн байна.

ГХБХБГазар, Барилга захиалагчийн алба нь барилга байгууламжид гүйцэтгэх графикт хугацааны дагуу үе шат болгонд хяналт тавьж, техникийн хяналтыг хэрэгжүүлж илэрсэн зөрчлийг барилга байгууламжийн талбайн хяналтын дэвтэрт тухай бүрт тэмдэглэж, зөрчлийг арилгуулж ажилласан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжих барилга, засварын ажлын 6 төсөл, арга хэмжээнд "АЕСН" ХХК, 3 төсөл, арга хэмжээнд "Зэд прожект" ХХК, 9 төсөл, арга хэмжээнд бусад зураг төсөв зохиогч компаниуд хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилгын ажил, аймгийн төвийн 3.1 км хатуу хучилттай авто замын ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, зөрчлийг арилгуулж ажилласан байна.

Б.2.3. Хөрөнгө оруулалтаар авсан зарим тоног төхөөрөмж хэрэглэгчдэд бүрэн хүрээгүй байна

ТЕЗ-даас эрх шилжиж хэрэгжсэн 22 төсөл арга хэмжээний 8 нь машин, тоног төхөөрөмж, 1 зөвлөх үйлчилгээ худалдан авах төсөл арга хэмжээ байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцаас 1, Эрүүл мэндийн сайдын багцаас 7 төсөл арга хэмжээ хэрэгжсэн байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцаас эрх шилжсэн нийт 500.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Ерөнхий боловсролын сургуулиудад компьютерийн лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, арга хэмжээг 11 багц болгон тендер зарлаж, шалгарсан 9 компанитай тоног төхөөрөмжийг 453.0 сая төгрөгөөр нийлүүлэхээр гэрээ байгуулсан байна.

Тендерт шалгарсан 9 аж ахуйн нэгжээс 8 нь гэрээний дагуу компьютерийн лабораторийн тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлж, багц-1, 8-д шалгарсан "Ахтай" ХХК 60.0 сая, багц-2, 9-д шалгарсан "Файвер оптик констракшн" ХХК 62.5 сая, багц-3-д шалгарсан "Нурбах" ХХК 29.5 сая, багц-4, 6, 7-д шалгарсан "Ернур" ХХК 89.5 сая, багц-5-д шалгарсан "Кен дала" ХХК 30.0 сая, багц-11-д шалгарсан "Сод электроникс" ХХК 71.3 сая, нийт **343.0** сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлж, Аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан комисст хүлээлгэн өгчээ.

Харин 10-р багцад шалгарсан "Монтех Дистрибьюшн" ХХК "Ковид-19" цар тахлын улмаас БНХАУ-ын Эрээн-Замын Үүдийн боомтын үйл ажиллагаа тодорхой бус хугацаагаар хаагдсанаас 110.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг гэрээний дагуу нийлүүлж чадаагүй, санхүүжилт олгогдоогүй байна.

Дээрх нийлүүлсэн 343.0 сая төгрөгийн компьютер, багаж хэрэгслийг Алтай, Алтанцөгц, Бугат, Булган, Буянт, Ногооннуур, Толбо, Улаанхус, Цэнгэл сумуудын Ерөнхий боловсролын сургуулиудад тус бүрт нь 30 ш компьютер, 30 ш компьютерийн

ширээ сандал, 9ш багшийн ширээ, сандал, 9 ш хувилагч принтер олгохоор хуваарилсан байна.

Аудитын явцад төсөл арга хэмжээний хэрэгжилтийг шалгаж үзэхэд Буянт, Ногооннуур, Цэнгэл сумын Ерөнхий боловсролын сургуульд тус бүрт 28 ш компьютер олгож, Аймгийн Засаг даргын тамгын газарт **5.6 сая** төгрөгийн үнэтэй 6 ш компьютерийг “түр ашиглана” гэсэн нэрийдлээр авч үлдсэн байна.

Аудитын дүнгээр хууль бусаар ашиглаж байгаа **5.6 сая** төгрөгийн компьютерийг Буянт, Ногооннуур, Цэнгэл сумын ерөнхий боловсролын сургуулиудад буцаан олгож зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлэв.

Эрүүл мэндийн сайдын багцаас эрх шилжсэн 550.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сумын эрүүл мэндийн төв, сум дундын эмнэлгийн /Дэлүүн, Улаанхус, Цэнгэл/ тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, арга хэмжээг орон нутгаас 4 багц болгон тендер зарлаж шалгарсан 4 компани нийт 483.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ байгуулсан байна.

Тендерт шалгарсан 4 аж ахуйн нэгжээс багц 1-д шалгарсан "Ариун мед Трейд" ХХК 96.6 сая, багц 4-д шалгарсан "Биомед трейд" ХХК 94.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлж, багц 2-д шалгарсан "Сүвэн уул" ХХК 116.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг нийлүүлж, 19.3 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг "Ковид-19" цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан нийлүүлж амжаагүй тул үлдэгдэл санхүүжилтийг барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан байна.

Харин 3-р багцад шалгарсан "Еба констракшн" ХХК нь **155.7 сая** төгрөгийн тоног төхөөрөмжийг бүрэн нийлүүлсэн гэж хүсэлт гаргасныг Аймгийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн А/976 дугаар захирамжаар байгуулсан тоног төхөөрөмжийг хүлээн авах комисс гэрээг дүгнэх маягтаар "Еба констракшн" ХХК-ны гэрээг 100% гэж дүгнэж, комиссын 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 39 тоот актаар **155.7 сая** төгрөгийн тоног төхөөрөмжийг бүрэн хүлээн авснаар гарын үсэг зурж баталгаажуулж, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Аудитын явцад төсөл арга хэмжээ хэрэгжсэн байгууллагуудаас шалгаж үзэхэд **6.3 сая** төгрөгийн үнэ бүхий 14 ширхэг үзлэгийн орыг дутуу нийлүүлсэн нь тогтоогдож нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

Эмнэлгийн тоног төхөөрөмжүүдийг хуваарилахдаа Дэлүүн сумын Эрүүл мэндийн төвд 115.4 сая төгрөгийн, Улаанхус сумын Эрүүл мэндийн төвд 112.6 сая төгрөгийн, Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвд 130.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хуваарилж, төсөл арга хэмжээнд нэр нь ороогүй аймгийн Нэгдсэн эмнэлэгт 78.5 сая төгрөгийн, Сагсай сумын Эрүүл мэндийн төвд 10.1 сая төгрөгийн, Бугат сумын Эрүүл мэндийн төвд 9.4 сая төгрөгийн, нийт **98.0 сая** төгрөгийн тоног төхөөрөмжийг зохих шийдвэргүйгээр хуваарилж олгосон байна.

Аудитын дүнгээр Нэгдсэн эмнэлэг, Бугат, Сагсай сумын Эрүүл мэндийн төвд шилжүүлсэн үндсэн хөрөнгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас шийдвэр гаргуулж тухайн байгууллагуудад олгох, Улсын Их хурлаас баталсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтыг дур мэдэн өөрчилж хөрөнгө хуваарилсан зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэв.

Дээрхи гарсан зөрчлүүд нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийг ашиглалтад хүлээн авах комисс бүрд Орон нутгийн өмчийн газрын төлөөллийг оролцуулаагүй байгаагаас ашиглагч байгууллагууд хөрөнгийг

данс бүртгэлд тусгасан эсэхэд тухай өмчийн хяналт хэрэгжихгүй байгаатай холбоотой байна.

Иймд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн барилга байгууламж, хөрөнгө, тоног төхөөрөмжийг хүлээн авах комисст Орон нутгийн өмчийн газрын төлөөллийг заавал оролцуулж ажиллахыг аймгийн ЗДТГ-т зөвлөмж болгов.

Б.2.4. Тус аймагт өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй орхигдсон 7 барилга байгууламж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна

Баян-Өлгий аймгийн хэмжээнд өмнөх онуудаас хэрэгжиж дуусаагүй орхигдсон нийт 7 барилга, байгууламж байна. Үүнд:

- Цэнгэл сумын 360 суудалтай Тыва бага сургууль, Ногооннуур сумын 105 суудалтай Спорт цогцолбор, Өлгий сумын Хотгор багийн Эрүүл мэндийн төв, Бугат сумын 300 суудалтай Соёлын төвийн барилга, Өлгий сумын 900 айлын хорооллын инженерийн шугам сүлжээний ажил төсөвт өртгийн зөрүүгээс болж 2020 онд ашиглалтад ороогүй, 2021 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй байна.
- Цэнгэл сумын 150 хүүхдийн дотуур байрны барилгын ажлыг "Алтайн газрын хүч" ХХК 100 хувь гүйцэтгэж дуусгасан боловч гадна шугам сүлжээний ажил нь зураг төсөлд тусгагдаагүйгээс нэмэлт 139.0 сая төгрөгийн хөрөнгийг шийдвэрлэх хүртэл ашиглалтад өгөхгүй гэж барилгын ажлыг зогсоосон байна. 2021 оны төсөвт хөрөнгө тусгагдаагүй.
- Өлгий сумын Үерийн усны хамгаалалтын далан суваг, өмнөх оны төсөвт санхүүжилт батлагдаагүй, 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн байна.

Б.2.5. Барилга байгууламжийн 4 төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төслийг барилгын норм, дүрэм, стандартын дагуу боловсруулсан байна

Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 2020-2021 онд эрх шилжүүлсэн барилга байгууламжийн 14 төсөл, арга хэмжээнээс 4 төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төслийг барилгын норм, дүрэм, стандартын дагуу боловсруулж төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд ашигласан байна.

Харин Улаанхус сумын Хөх хөтөл багийг шилэн кабельд холбох, зураг төсөв боловсруулах ажил, Өлгийн сумын Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга, Хүнс, хөдөө аж ахуйн газар, лабораторийн барилга, Өлгий сумын 100 ортой цэцэрлэгийн барилга 2 ш, Өлгий сумын 940 суудалтай сургуулийн барилга, спорт заал, Хүнс хөдөө аж ахуйн газар, лабораторын барилга, Баяннуур сумын Ах арал багийн 50 ортой цэцэрлэгийн барилга, Булган сумын Сайхан багийн 50 ортой цэцэрлэгийн барилга, Ногооннуур сумын Улаанхад багийн 5 ортой эрүүл мэндийн төвийн барилга, Ногооннуур сумын Улаанбайшинтын 50 ортой цэцэрлэгийн барилга зэрэг 10 төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг барилгын норм, дүрэм, стандартын дагуу боловсруулж бэлэн болгоогүй байна.

Б.3. Төсөл арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна

Б.3.1 Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлсэн боловч үр дүнг тооцсон талаар баримт бүрдүүлээгүй байна

ТЕЗ-даас эрх шилжүүлсэн 22 төсөл арга хэмжээ, тендерийн маргаанаас 2020 оноос дамжин хэрэгжиж байгаа 6 төсөл арга хэмжээ, бүгд 28 төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна.

ГХБХБГ-аас эрх шилжсэн, он дамжсан төсөл арга хэмжээнд үе шатны хяналтыг хэрэгжүүлж, төсөл арга хэмжээ тус бүрийн мэдээлэл, ажлын явцыг баримтжуулж, гарч буй хүндрэл бэрхшээлийн талаар товч мэдээлэл бэлтгэсэн байна. Тухайлбал:

- Алтанцөгц сумын сургуулийн хичээлийн А байр, биеийн тамирын заалны их засварын ажилд барилгын ажлыг хурдан шуурхай, чанарын өндөр түвшинд хугацаанд хүлээлгэж өгөх, дээврийн модон материалыг нэвчилтээс хамгаалах бодис түрхэх, Баяннуур сум, Акарал багийн 50 ортой цэцэрлэгийн барилгын ажилд бүх цонхыг буулгаж зургийн дагуу хийх, дотор 3 хаалганы ялууг буулган зургийн дагуу хийх үүрэг даалгавар өгсөн.
- Төрийн үйлчилгээний Нэгдсэн төвийн барилга, Өлгий сум “Кутты мекен” хотхоны цэцэрлэгийн барилга, Бугат сумын Халуун усны барилга, Улаанхад багийн Эрүүл мэндийн барилга, Хүнс хөдөө аж ахуйн газрын лабораторийн барилга, Ногооннуур сум, Улаанбайшинт цэцэрлэгийн барилга, Өлгий сумын 940 суудалтай сургуулийн барилга, спорт заал зэрэг төсөл арга хэмжээний хэрэгжилтэд үе шатны хяналтыг хэрэгжүүлсэн байна.

ГХБХБГ-аас төсөл арга хэмжээ тус бүрд хэдэн удаа шалгалт явуулсан, гарсан зөрчил дутагдлыг арилгаж үр дүнг тооцсон талаар баримт материалыг ирүүлээгүй болно.

Төсөл арга хэмжээний санхүүгийн баримт материал, санхүүжилт хүссэн ажлын гүйцэтгэлийн баримтаар зураг төслийг боловсруулсан байгууллагын зохиогчийн хяналтыг хэрэгжүүлсэн ажлын баримтууд хавсаргаж, зураг төслийн хяналтын зардлыг Санхүү, төрийн сангийн хэлтсээс олгож ирсэн байна.

Б.3.2 Төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгож ирсэн байна

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 14.5, 14.6-д заасны дагуу гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлийг үндэслэн захиалагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан эрх олгосон албан тушаалтнаас хянасны дараа “хяналтын хүснэгт”, “барилга засвар, их засварын ажлын гүйцэтгэл”-ийг бөглөж, Сангийн яаманд хүргүүлж журамд заасан хугацаанд санхүүжилтийг олгосон байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс ажлын гүйцэтгэл, “хяналтын хүснэгт”, “барилга засвар, их засварын ажлын гүйцэтгэл”, ажил гүйцэтгэгчийн нэхэмжлэл зэрэг нотлох баримтуудыг үндэслэн урьдчилгаа болон эцсийн санхүүжилтийг журамд заасан хугацаанд олгож ирсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2019-2021 онд эрх шилжиж ирсэн 34150.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй нийт 28 төсөл арга хэмжээний тайлант онд

санхүүжилтэд 11334.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 6707.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба 10028.5 сая төгрөгийн бодит гүйцэтгэлтэй байна.

Үүнээс: Засгийн газрын 2021 оны 15 дугаар тогтоолоор ЗТХС-ын багцаас шилжсэн 2880.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээний зөвхөн тендерийн эрх нь шилжиж санхүүжилтийг орон нутгаар дамжуулаагүй яамнаас шууд олгожээ.

Санхүүжилт олгосон байдлыг төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр харуулбал.

Хүснэгт №04

ТЕЗ-ийн нэр	ТАХ-ний тоо	Төсөвт өртөг	Тухайн онд санхүүжих дүн	Олгосон нийт санхүүжилт	Бодит гүйцэтгэл	Хувь
ЗГХЭГ	2	8101.4	1916.0	1583.1	5533.1	68%
ХНХС	1	1,930.0	422.40	422.40	422.40	22%
ХХААХҮС	1	1,913.2	500.0	500.0	500.0	26%
БСШУССайд	12	18750	6318.9	2178.7	2248.7	12%
Эрүүл мэндийн сайд	7	1,381.6	1381.6	1223.6	1223.6	89%
БХБСайд	2	2,074.3	795.1	95.1	95.1	5%
ССайд	1	1683.2	1000.0	0	0	0%
ЗТХС	2	2880.0	1080.0	-	-	-
Нийт	28	34150.5	11334	6002.9	10022.9	

Эх сурвалж: УТХО-ын гүйцэтгэлийн судалгаа

Тайлант онд ЭМЯ-ны багцаас санхүүжүүлсэн 4, БШУС-ын багцаас санхүүжүүлсэн 1, ЗТХЯ-ны багцаас санхүүжүүлсэн 2 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна.

Б.3.3 Хөрөнгө оруулалтын явцад Төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналтыг хэрэгжүүлж ажилласан байна

Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс эрх шилжсэн хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлийг хянах, санхүүжилтийг олгоход үе шатны хяналтыг хэрэгжүүлж, холбогдох журмыг мөрдөж ажилласан байна.

Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 14.5-д заасны дагуу захиалагчийн санхүүжилт хүссэн материалыг хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн хянан баталгаажуулсны дараа албан бичгээр холбогдох гүйцэтгэлийн материалын хамт Сангийн яаманд хүргүүлж, Сангийн яамнаас санхүүжилтийн эрхийг нээж Санхүү, төрийн сангийн хэлтсээс санхүүжилтийг хугацаанд олгож ирсэн байна.

Зураг төсвийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг холбогдох материалыг үндэслэн шилжүүлжээ.

Аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний гүйцэтгэлд аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас хяналт хэрэгжүүлээгүй байна.

Б.4. Засгийн газраас гарсан шийдвэрийн хэрэгжилт үр дүнтэй болсон байна

Б.4.1. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан санхүүжилтийг төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд зарцуулсан байна

Засгийн газрын 2021 оны “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар авах зарим арга хэмжээний тухай” 397 тогтоолоор Монгол Улсад коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын тохиолдол бүртгэгдэж бүх нийтийн бэлэн байдал болон өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнээс шалтгаалан 2021 онд хэрэгжиж дуусаагүй дараах төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн аймгийн Төрийн сан дахь хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршуулсан байна. Үүнд:

Улаанхус сумын Эрүүл мэндийн төвийн нярайн халаах төхөөрөмж, инкубатор нийлүүлэх ажлын 4.3 сая төгрөг, Улаанхус, Дэлүүн, Цэнгэл сумын Эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж нийлүүлэх ажлын 19.4 сая төгрөг, Ногооннуур сумын Улаанхад багийн 5 ортой Эрүүл мэндийн төвийн барилгын ажлын 41.2 сая төгрөг, Хот тохижилт паркийн шинэчлэлийн ажлын 700.0 сая төгрөг, Толбо сумын Соёлын төвийн барилгын ажлын 1,000.0 сая төгрөг, Улаанхус сумын Хөх хөтөл багийг шилэн кабелд холбох ажлын 167.0 сая төгрөг /1-р багц, “Классиксолюшн” ХХК/, мөн шилэн кабелд холбох ажлын 165.9 сая төгрөг /5-р багц “Файвер оптик” ХХК/, Өлгий сумын “Кутты мекен” хотхоны 120 ортой цэцэрлэгийн барилгын ажлын 400.0 сая төгрөг, Ногооннуур сумын Улаан байшинт 50 ортой цэцэрлэгийн барилгын 356.5 сая төгрөг, Өлгий сумын 250 ортой цэцэрлэгийн барилгын ажлын 501.4 сая төгрөг, Өлгий сумын 100 ортой цэцэрлэгийн барилгын ажлын 300.0 сая төгрөг /“Классиксолюшн ХХК/ нийт 3655.7 сая төгрөгийг жилийн эцэст хөрөнгө оруулалтын барьцаа дансанд төвлөрүүлжээ.

Баяннуур сумын сургуулийн А корпус, спорт заалны засварын ажлын санхүүжилтийн үлдэгдэл 74.9 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн Театрт лед дэлгэц, хөгжим худалдан авах санхүүжилтийн үлдэгдэл 5.7 сая төгрөгийг барьцаа хөрөнгийн данснаас чөлөөлж тухайн аж ахуйн нэгжүүдийн дансанд шилжүүлсэн байна.

Б.4.2. Засгийн газраас ТЕЗ-ийн барьцаа хөрөнгийн дансанд өмнөх онуудад байршуулсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна

Хөрөнгө оруулалтын барьцаа дансанд 2019 оноос эхлэн дутуу хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үлдэгдэл санхүүжилтийг байршуулж эхэлсэн бөгөөд Засгийн газрын 2019 оны 430 дугаар тогтоолын дагуу тухайн онд хөрөнгө оруулалтын барьцаа дансанд нийт 64.5 сая төгрөг байршуулж, 54.0 сая төгрөгийг Сагсай сумын 125 ортой хүүхдийн цэцэрлэгийн дутуу санхүүжилтэд олгож, жилийн эцэст 10.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Засгийн газрын 2020 оны 253 дугаар тогтоолын дагуу 2020 онд Баяннуур сумын сургуулийн А корпус, спорт заалны засварын ажлын санхүүжилтийн үлдэгдэл 74.9 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн Хөгжимт драмын театрт лед дэлгэц, хөгжим худалдан авах санхүүжилтийн үлдэгдэл 5.7 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын барьцаа дансанд төвлөрүүлж, Буянт сумын халуун усны барилгын ажлын 10.5 сая төгрөгийг буцаан олгосон байна.

Б.5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцож ажиллаагүй байна

Б.5.1. Нийлүүлсэн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг данс бүртгэлд бүрэн тусгаагүй, хүчин чадлаар нь зориулалтын дагуу ашиглаагүй байна

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж эрх шилжсэн 22 төсөл арга хэмжээний 8 нь тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл арга хэмжээ бөгөөд 6 төсөл арга хэмжээ нь Эрүүл мэндийн сайдын багцаас, 1 төсөл арга хэмжээ нь Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцаас, 1 төсөл арга хэмжээ нь Барилга, хот байгуулалтын сайдын багцаас тус тус эрх шилжсэн байна.

Ерөнхий боловсролын сургуулиудын компьютерийн лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендерээр нийтдээ **343.0** сая төгрөгийн үнэтэй тоног төхөөрөмжийг гүйцэтгэгч компаниуд нийлүүлж 9 сумын Ерөнхий боловсролын сургууль тус бүрт 30 ш компьютер, 9 ш хувилагч принтер, 30 ш компьютерийн ширээ сандал, 9 ш багшийн ширээ, сандалыг хуваарилж, данс бүртгэлд орлого авхуулсан байна.

Аудитын явцад сумын Ерөнхий боловсролын сургуулиудын хүлээн авсан тоног төхөөрөмжийг орлого авсан эсэх, бүрэн хүчин чадлаар нь ашиглаж байгаа эсэхийг шалгахад Цэнгэл сумын Ерөнхий боловсролын сургууль “Ернур” ХХК-аас нийлүүлсэн 28 ш суурийн компьютер, багшийн ширээ сандал нийт **7.4 сая** төгрөгийн хөрөнгийг орлого аваагүй байна.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын сургуульд “Кен дала” ХХК-ны нийлүүлсэн 935.0 мянган төгрөгийн 1 ш суурийн компьютер, Алтай сумын Ерөнхий боловсролын сургуульд “Ахтай” ХХК-ны нийлүүлсэн 929.2 мянган төгрөгийн 1 ш суурийн компьютер, Булган сумын Ерөнхий боловсролын сургуульд “Файвер оптик констракшн” ХХК-аас нийлүүлсэн 5.0 сая төгрөгийн 5 ш суурийн компьютер, нийт **6.9 сая** төгрөгийн үнэтэй 7 ш суурийн компьютер нь эвдэрхий, ашиглах боломжгүй байна.

Аудитын дүнгээр орлого аваагүй **7.4** сая төгрөгийн компьютер, багшийн ширээ сандалыг орлого авч бүртгэлд тусгуулах, эвдэрхий **6.9 сая** төгрөгийн компьютерийг тендерийн гүйцэтгэгч компаниудаар засварлуулах эсвэл солиулах арга хэмжээ авч зөрчлийг арилгах талаар албан шаардлага хүргүүлэв.

Эрүүл мэндийн сайдын багцаас эрх шилжсэн 550.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Сумын эрүүл мэндийн төвийн тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шалгаж үзэхэд Цэнгэл сумын Эрүүл мэндийн төв 34.4 сая төгрөгийн, Сагсай сумын Эрүүл мэндийн төв 10.1 сая төгрөгийн, Бугат сумын Эрүүл мэндийн төв 9.4 сая төгрөгийн, нийт **53.9 сая** төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг орлого авч данс бүртгэлд тусгаагүй байна.

"Еба констракшн" ХХК-ны нийлүүлсэн 149.4 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хүлээн авсан эмнэлгүүд нь НӨАТ-ыг оруулаагүй дүнгээр 140.4 сая төгрөгөөр бүртгэлд тусгаж **14.5 сая** төгрөгөөр зөрүүтэй үнээр орлого авч тайлагнасан байна.

Аудитын дүнгээр данс бүртгэлд тусгаагүй нийт **53.9 сая** төгрөгийн эмнэлгийн тоног төхөөрөмжийг үндсэн хөрөнгө дансанд бүртгэж орлого авхуулах, төсөл хэрэгжсэн эмнэлгүүдэд нийлүүлсэн **14.5 сая** төгрөгийн тоног төхөөрөмжийн үнийн зөрүүг орлого авч данс бүртгэлд тусгаж зөрчлийг арилгахыг албан шаардлага болгов.

Цэнгэл, Улаанхус, Ногоонуур, Буянт сумдад түргэн тусламжийн автомашин нийлүүлэх төсөл арга хэмжээг 2 багц болгон худалдан авах ажлыг зохион байгуулж, нийлүүлэгчийн хүсэлтээр 1-р багцын 2 ш УАЗ 31514 маркийн машиныг нийлүүлэх техникийн нөхцөлийг захиалагчийн зөвшөөрснөөр УАЗ 2206 маркийн машин болгон өөрчилсөн байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны 7 сарын 06-ны өдрийн А/592 тоот захирамжаар байгуулсан Автомашиныг хүлээн авах комиссын 2021 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 16 тоот актаар “Уаз Мега” ХХК-ны нийлүүлсэн 1-р багцын 2 ш УАЗ 2206 маркийн машиныг, 6 дугаар сарын 22-ны өдрийн 19 тоот актаар “ПГЖМ” ХХК-ны нийлүүлсэн 2-р багцын 2 ш УАЗ 2206 маркийн машиныг тус тус хүлээн байна.

Нийлүүлсэн машиныг ашиглагч байгууллагууд данс бүртгэлд тусгасан эсэхийг шалгаж үзэхэд Буянт сумын ЭМТөвд олгох УАЗ 2206 маркийн машины оронд аймгийн Нэгдсэн эмнэлгийн түргэний машин худалдан авах төсөл арга хэмжээнд нийлүүлсэн УАЗ 31514 маркийн хантер машиныг сольж олгосон байна.

Б.5.2. Төсөвт өртөг нь үндэслэлгүй нэмэгдсэн төсөл, арга хэмжээ байхгүй байна

Он дамжин хэрэгжсэн төсөл, арга хэмжээнээс Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилгын ажлыг 6898.0 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр 2019 онд гэрээ байгуулж, 2021 онд гэрээний дүнг 7501.4 сая төгрөг болгон өөрчилж нэмэлт гэрээ байгуулж гэрээний дүн 603.4 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Тус компани нь 2021 онд 1500.0 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэж санхүүжилт авсан байна. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн барилгаас өөр төсөвт өртөг нь нэмэгдсэн төсөл, арга хэмжээ байхгүй байна.

Б.5.3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна

Өмнөх онд хийсэн аудитаар Засаг даргын тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газарт 7 зөвлөмж, 2 албан шаардлага өгөгдсөн ба хэрэгжилт нь 80 %-тай байна.

Албан шаардлага бүрэн хэрэгжсэн бөгөөд 2 зөвлөмж 100 хувь, 2 зөвлөмж 80 хувь, 3 зөвлөмж 25-30 хувьтай хэрэгжсэн байна.

Өмнөх оны аудитаар төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төслийг урьдчилан хийлгэж, магадлалаар баталгаажуулсны дараа төсөвт оруулан батлуулж ажиллах, хугацаанаас хожимдуулж тендер зарлаж байгаа асуудалд дүгнэлт хийж, худалдан авах ажиллагааг түргэн, шуурхай зохион байгуулж ажиллах талаар өгсөн зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний тендерийн маргаан, газрын асуудалтай холбоотой гэрээний хугацааг сунгаж байгааг цаашид давтан гаргахгүй байх, тайланд онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний тайлан, гүйцэтгэлийг шилэн дансанд байршуулж ажиллах талаар өгсөн албан шаардлыг биелүүлээгүй байна.

Б.5.4. Тайлант онд хэрэгжихээр төлөвлөгдсөн төсөл арга хэмжээний 32 хувь нь ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл арга хэмжээнд чиглэгдсэн байна

Баян-Өлгий аймагт Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд Өлгий сумын Хүүхэд хамгаалал, хөгжлийн төвийн барилга ашиглалтад орсноор 10, Бугат сумын Халуун усны барилга 3, Хот тохижуулах албанд 2-3, 100 ортой хүүхдийн 2 цэцэрлэгт 25-28, Өлгий сумын 940 суудалтай сургуулийн барилга, спорт заалд 100, Ногооннуур сум, Улаан байшинт боомтын 50 ортой цэцэрлэгийн барилгад 8, Ногооннуур сумын Улаанхад багийн 5 ортой эрүүл мэндийн төвийн барилгад 6, нийт 158 ажлын байр шинээр бий болох боломжтой байна.

Улаанхус сумын Хөх хөтөл, Согог багийг шилэн кабельд холбосноор тухайн багийн нийт 1947 хүн ам цахимаар мэдээ мэдээлэл авах, сургууль, цэцэрлэгүүдийн сургалтын чанарт өөрчлөлт гарах боломж бүрдэх юм.

Тайлант онд хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн 32 хувь нь эдийн засгийн өсөлтийг дэмжих, ажлын байрыг нэмэгдүүлэх төсөл арга хэмжээнд чиглэгдсэн байна.

Б.5.5. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл, арга хэмжээний үр дүнд авто замын хүчин чадал 6.5 км-ээр нэмэгдсэн

Зам тээврийн хөгжлийн сайдын багцаас аймгийн төвд хатуу хучилттай 6.5 км авто зам баригдсанаар хатуу хучилттай замын хүчин чадал 6.5 км-ээр нэмэгдэж, тухайн замаар зорчих иргэдийн тавь тух, сэтгэл ханамж дээшилсэн байна.

ҮАГ-т хүргүүлэх санал:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчдаас орон нутагт төсөл, арга хэмжээний эрх шилжүүлэх хугацааг богиносгож, холбогдох хууль журамд өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.
2. Зураг төсөв, ТЭЗҮ нь бэлэн болоогүй, магадлалаар баталгаажаагүй төсөл, арга хэмжээнүүдийг Улсын Их Хурлаас Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад оруулан батлахгүй байхад анхаарах.
3. ТБОНӨХБАҮХАТухай хуульд тендерийн маргаан, гомдолтой холбоотой, тодорхой заалт оруулж, хариуцлагын асуудлыг оруулах.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээний 80.2 хувийг бодлогын баримт бичигт нийцүүлж төлөвлөсөн байна.
2. ТЕЗ-ийн саналд үндэслэгдээгүй 9 төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээнд оруулан баталсан байна.
3. Шинээр хэрэгжих барилга байгууламжийн 8 төсөл арга хэмжээний зураг төлөвлөлтийн шатанд бэлэн болоогүй байжээ.
4. Барилга байгууламжийн зураг төсөв хийгдээгүйгээс, магадлалаар баталгаажсан өртөг нь батлагдсан төсөвт өртгөөс материаллаг зөрүүтэй байна.
5. Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй байна.
6. Төсвийн ерөнхийлөн захирагчдаас 18-42 хоногоор хугацаа хэтрүүлж эрх шилжүүлжээ.
7. Зарим тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлээгүй, тендер шалгаруулалтыг хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байгаа нь гомдол гарахад нөлөөлсөн байна.
8. Захиалагч гэрээний хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж ажиллаагүй байна.
9. Хөрөнгө оруулалтаар авсан зарим тоног төхөөрөмж ашиглагч байгууллагуудад бүрэн хүрээгүй байна.
10. Төсөл арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна.
11. Барьцаа хөрөнгийн дансанд байршуулсан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.
12. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр нөлөөг тооцож ажиллаагүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

I. Аймгийн ЗДТГ-ын дарга Б.Мухамед, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Х.Анар нарт:

1. Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө холбогдох журмыг мөрдөж ажиллах;
- 2.Төлөвлөлтийн шатанд шинээр хэрэгжих төсөл арга хэмжээний зураг төслийг бэлтгэж, магадлалд оруулж баталгаажуулах, магадлалд ороогүй төсөл арга хэмжээг төсөл арга хэмжээний жагсаалтад тусгахгүй байх;
- 3.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, хөрөнгийг хүлээн авах комисст Орон нутгийн өмчийн газрын төлөөллийг заавал оролцуулж байх;

II. Орон нутгийн өмчийн газрын дарга Т.Назым-д:

1. Худалдан авах ажиллагааг хугацаанд нь төлөвлөж, зарим төсөл арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журамд нийцүүлээгүй, тендер шалгаруулалтыг хууль журмын дагуу зохион байгуулаагүйгээс гомдол гарч байгаа асуудалд дүгнэлт хийж, худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд төлөвлөж, аж ахуйн нэгжүүдийг ил тод, тэгш өрсөлдөх боломжоор хангаж ажиллах;
2. Тендерийг төлөвлөсөн хугацаанаас хожимдуулан зарлаж байгаа асуудалд дүгнэлт хийж, худалдан авах ажиллагааг хуулийн хүрээнд түргэн, шуурхай зохион байгуулж ажиллах;
- 3.Худалдан авах ажиллагааны тайланг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хугацаанд бүрэн байршуулан мэдээлж ажиллах;

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 11 дүгээр сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/факс: (976) 7042-3264

2022.04.29 № 8-03/451

танай _____ -ны № _____ -т

АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Танай байгууллагаас 2021 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын хөрөнгөөр гүйцэтгэсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн аудитын тайлантай танилцав.

Тухайн аудит нь холбогдох хууль, журмын дагуу хийгдсэн гэж үзэж байна. Тайлантай холбоотой ямар нэгэн саналгүй болно.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ,
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА



Х.АНАР

0108220832